

2008.10.22

Дугаар 228

Хөрөнгийн зах зээлийг 2009-2012 онд  
хөгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэл батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 2.1 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.2 дах заалтыг үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Хөрөнгийн зах зээлийг 2009-2012 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсугай.

2. Сангийн яам, Монголбанктай хамтран ажиллах гурван талт харилцан ойлголцлын санамж бичигт тусгах, зарим тэргүүлэх чиглэлээр төсөл боловсруулан олон улсын байгуулага бусад хандивлагчдад хандан санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх зэргээр энэхүү үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Хорооны дарга /Д.Баярсайхан/-нд үүрэг болгосугай.

3. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг Ажлын алба (О.Ганбат)-нд үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

Хорооны 2008 оны 10 дугаар сарын 22-ны  
өдрийн 228 тоот тогтоолын хавсралт

## **ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙГ 2009-2012 ОНД ХӨГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮНДСЭН ЧИГЛЭЛ**

### **ОРШИЛ**

Хөрөнгийн зах зээлийг дунд хугацаанд хөгжүүлэх талаар Хорооноос баримтлах бодлогыг тодорхойлох зорилгоор “2009-2012 онд хөрөнгийн зах зээлийн талаар авах арга хэмжээний үндсэн чиглэл” /цаашид “үндсэн чиглэл” гэх/-ийг батлав.

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан үндсэн чиглэлийн цогц бодлогыг хэрэгжүүлэхэд олон улсын нийтлэг жишиг, хөрөнгө оруулагчдын шаардлагад нийцсэн сайн засаглал бүхий үндэсний нээлттэй компаниудыг байгуулах, хөрөнгийн зах зээлээр дамжуулан үндэсний эдийн засагт урт хугацааны хөрөнгө оруулалтыг татах эрх зүй, зохицуулалтын таатай орчныг бүрдүүлэх асуудал зайлшгүй тавигдаж байна.

Энэ нь Хорооноос хөрөнгийг зах зээлийн өнөөгийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тогтоох бодит үндэслэл болж байна.

**Үндсэн чиглэлд хөрөнгийн зах зээлийн эрх зүйн орчин, дэд бүтэц, төрийн хяналт, зохицуулалтыг олон улсын жишигт хүргэх замаар улс орны эдийн засагт энэ зах зээлийн эзлэх байр суурийг нэмэгдүүлэх үндсэн зорилгыг дэвшүүлж байна.**

Үндсэн чиглэлийг Санхүүгийн зохицуулах хороо, Сангийн яам, Монгол банк, үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллагууд, тэдгээрийн эрх ашгийг төлөөлөх төрийн бус байгууллага, үнэт цаас гаргагчид, эрдэм шинжилгээний байгууллагууд, иргэд олон нийтийн саналыг авсны үндсэн дээр боловсруулсан болно.

Сүүлийн үед хөрөнгийн зах зээл дээр гадаадын хөрөнгө оруулагчдын оролцоо нэмэгдсэний үр дүнд цөөн тооны үнэт цаасны арилжаа идэвхижиж, ханш өссөнийг дагаад зах зээлийн үнэлгээ нэмэгдэх хандлага ажиглагдаж байгаа боловч бүртгэлтэй компанийн тоотой харьцуулахад бага, ДНБ-д эзлэх хувь шалихгүй хэвээр байгаа нь олон улсын жишгээс ихээхэн зөрүүтэй байгаа бөгөөд эдийн засгийн бодит салбарын санхүүжилтэд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувь бага, банкны салбар давамгайлсан хэвээр байна.

Дэлхийн банк, Олон улсын валютын сан, Азийн хөгжлийн банк зэрэг олон улсын байгууллагуудаас хийсэн үнэлгээний тайлангууд д ч ингэж дүгнэж байна.

Хөрөнгийн зах зээлд тулгамдаж буй асуудлыг дараах чиглэлээр тодорхойлж, үүнд үндэслэн цаашдын зорилго, зорилтыг тодорхойлсон болно.

1. Монгол улсад 1990-ээд оны эхээр өмч хувьчлах ажиллагааг холбогдох хууль эрх зүйн орчин, төрөөс хяналт тавих байгууллага, шүүх хяналтын байгууллагын ажилтнуудыг сургах зэрэг урьдчилсан бэлтгэлийг бүрэн хангалгүй эхлүүлсэн, ард

иргэдийн хөрөнгийн зах зээлийн талаар ойлголт сул байсан зэрэг олон асуудал хөрөнгийн зах зээлийн хөгжилд өнөөг хүртэл нөлөөлсөөр байна.

2. Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчин, хяналт, зохицуулалт шаардлагын түвшинд хүрээгүй байна.

3. Үнэт цаасаар хөрөнгө оруулалт хийх сонголт хязгаарлагдмал, энэ зах зээлийн талаар ард иргэдийн мэдлэг, ойлголт сул, мэдээлэл авах боломж муу, нөгөө талаар хамтын хөрөнгө оруулалтын байгууллага хөгжөөгүй учраас үнэт цаасаар хийх хөрөнгө оруулалт шаардлагын түвшинд хүрэхгүй байна.

4. Үнэт цаас гаргах замаар санхүүжилтийн эх үүсвэр татах боломжийг бизнес эрхлэгчид болон Засгийн газар, аймаг, орон нутгийн засаг захиргаа тэр бүр ашиглаж чадахгүй байгаа, ашигт малтмалын орд газрын ашиглалтыг санхүүжүүлэх асуудлаар төрөөс баримтлах бодлого тодорхойгүй, үл хөдлөх хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны зах зээл хөгжөөгүй зэргийн улмаас зах зээлийн нийлүүлэлт бага байна.

5. Үнэт цаасны зах зээлийн дэд бүтэц өнөөгийн шаардлагад нийцэн төлөвшиж чадаагүй байна.

## **ХОЁР. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТ**

### **2.1. Үндсэн чиглэлийн зорилго**

Энэхүү үндсэн чиглэлийн зорилго нь үнэт цаасны зах зээлийн эрх зүйн орчин, дэд бүтэц, хяналт, зохицуулалтыг сайжруулан олон улсын жишигт хүргэх, улс орны эдийн засгийн өсөлтөд хөрөнгийн зах зээлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүгийн салбарын тэнцвэртэй, тогтвортой хөгжлийг хангахад оршино.

### **2.2. Үндсэн чиглэлийн зорилтууд**

2.2.1. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн хувьчлалын зарим сөрөг үр дагаврыг залруулах арга хэмжээ

2.2.1.1. Хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хувьцаа эзэмшигч болсон иргэд төвлөрсөн хадгаламжид дансаа нээлгэх ажиллагааг дуусгах тодорхой хугацаа тогтоох талаар УИХ-д санал хүргүүлэх, тогтоосон хугацаанд дансаа нээлгээгүй, үлдэгдлээ шалгаж баталгаажуулаагүй иргэдийн дансанд байгаа хөрөнгийг төвлөрүүлэн хадгалах, оновчтой удирдан, үр ашигтай хэлбэрээр байршуулах, шаардсан үед нь буцаан олгох зохистой хэлбэрийг сонгон хэрэгжүүлэх;

2.2.1.2. Өмч хувьчлалын явцад үүсэн бий болж, Хөрөнгийн биржийн жагсаалтад бүртгэгдсэн компанийг зэрэглэх, Хөрөнгийн биржийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй байгаа компанийг бүртгэлээс хасах, үйл ажиллагаа нь зогссон боловч хөрөнгө нь байгаа компанийг дахин хөрөнгөжүүлэх үйл ажиллагаанд боломжтой дэмжлэг үзүүлэх, хөрөнгө нь үрэгдсэн компанийг татан буулгах арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлэх ингэхдээ ХОЭБ-ээр хувьцаа эзэмшсэн иргэдийн өмчлөх эрхийг аль болох хохиролгүйгээр шийдвэрлэх;

2.2.2. Зах зээлийн дэд бүтцийг бэхжүүлэх, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх

Хөрөнгийн зах зээлийн дэд бүтэц гэдэгт өөрийн зохицуулалттай байгууллага болох арилжаа эрхлэх байгууллага, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага, тусгай зөвшөөрөл бүхий зах зээлийн мэргэжлийн байгууллагуудын санхүүгийн болон үйл ажиллагааны чадавхи, стандарт, эрх, үүрэг, хариуцлага, үйлчилгээний чанар, хүртээмж, эрсдлээс сэргийлэх чадвар зэргийг хамааруулан ойлгоно.

Зах зээлийн дэд бүтцийг бэхжүүлэхэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

1. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг өнөөгийн шаардлагад нийцүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчинг бүрдүүлэн, өөрийн зохицуулалттай болон мэргэжлийн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, нөхцөл, хөрөнгө, санхүү, хүний нөөцийн чадавхид тавигдах шаардлагыг өндөрсгөн, эрх хэмжээ, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгоно.

Хөрөнгийн зах зээлд оролцогчдын хооронд гарсан маргааныг шуурхай шийдвэрлэхэд тус дөхөм болох шүүхээс гадуур маргаан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар санал боловсруулан эрх бүх байгууллагад хүргүүлэн, шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

Хөрөнгийн зах зээлд оролцогчдын хууль бус ажиллагаанд ногдуулах хариуцлагын хэм хэмжээг чангатгаж, хэрэг бүртгэлийн ажиллагааг зохицуулах байгууллага шуурхай гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх чиглэлээр эрүүгийн болон эрүүгийн байцаан шийтгэх хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлнэ.

Өөрийн зохицуулалттай байгууллага гишүүдийн мэргэжлийн ёс зүйн дүрэм, стандартыг тогтоон мөрдүүлж, зөрчил дутагдал гаргасан тохиолдолд хууль зүйн хариуцлагаас гадна мэргэжлийн ёс зүйн хариуцлага хүлээдэг байх нөхцлийг бүрдүүлнэ.

2. Хороо, зах зээлийн өөрийн зохицуулалттай болон мэргэжлийн байгууллагуудын техник, технологи, програм хангамжийн түвшинг сайжруулах замаар үйлчилгээний найдвартай байдал, хүртээмжийг дээшлүүлж, зардлыг бууруулан, арилжааны явцад хяналт тавих, гадаад орны зах зээлтэй харилцах, хамтран ажиллах боломжийг нэмэгдүүлнэ.

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын техник, технологийг шинэчилж, арилжааны найдвартай байдлыг ханган, интернет арилжаа эрхлэх нөхцлийг бүрдүүлж, оршин суугаа газраас үл хамаарч иргэд үнэт цаасны арилжаанд оролцох боломжийг шинээр бий болгон, арилжаанд оролцогчдын хүрээг өргөжүүлэх арга хэмжээ авна.

Гишүүдэд нь хувьцаа эзэмшүүлэх, өнөөгийн олон улсын практик шаардлагад нийцсэн сайн менежменттэй байх шаардлага зэргийг харгалзан Монголын хөрөнгийн биржийг хувьчлах оновчтой хэлбэрийг сонгон хувьчилна.

Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллагын үйл ажиллагааны горимыг олон улсын жишгийн дагуу шинэчилж, уг байгууллага нь өөрийн дансанд арилжаанд оролцогчдын мөнгөн хөрөнгийг хадгалж, уг хөрөнгийг өөрийн

сонгосон арилжааны банкинд өмчлөгчийн оролцоогүйгээр байршуулж байгаа өнөөгийн тогтолцоог өөрчлөн, эрсдэлийг бууруулах арга хэмжээ авна.

Өөрийгөө зохицуулах байгууллагуудтай хамтран үнэт цаасны зах зээлийн тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн техник болон програм хангамжийг магадлан итгэмжилж, гэрчилгээжүүлэх журамд шилжих, үүний үндсэн дээр цаашид техник, технологийн чадавхи, боломжийн хувьд олон улсын хөрөнгийн зах зээлтэй холбогдох бодлого баримтална.

Харилцагчийн цахим кодтой дэвтэр, электрон гарын үсэг ашиглах боломжийг нэвтрүүлж, нэг талаас үнэт цаасны зах зээл дээрх баримтын эргэлтийн нэгдсэн систем бий болгох нөгөө талаас харилцагчийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын найдвартай тогтолцоог бүрдүүлнэ.

Бүх аймаг, сумдад оршин сууж буй харилцагчдыг хамруулах боломжтой үнэт цаасны төлбөр тооцоо, мэдээлэл солилцооны дэд бүтцийг бий болгоно. Үүнд банкуудыг зуучлагчаар оролцуулах асуудлыг судлан, хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

3. Мэргэжлийн байгууллагад ажиллах боловсон хүчин шинээр бэлтгэх, одоо ажиллаж байгаа мэргэжилтнүүдийн чадавхийг сайжруулах арга хэмжээ авна. Үүний тулд эдийн засаг, санхүүгийн мэргэжилтэн бэлтгэж буй их дээд сургуулиудын хөрөнгийн зах зээлээр мэргэшүүлэх хөтөлбөрийг зохих байгууллага, мэргэжилтнүүдийн оролцоотойгоор боловсруулж, сургалтыг эхлүүлэн, сургалтын чанарыг дээшлүүлнэ. Түүнчлэн, давтан сургах, мэргэжил дээшлүүлэх богино хугацааны сургалт, дадлагын хөтөлбөр гаргаж, мэргэжлийн үйлчилгээний горим, заавар, зөвлөмж, гарын авлага боловсруулан мөрдүүлэх, нийтэд таниулах ажлыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, нэгдсэн систем бүрдүүлнэ.

Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын хөрөнгийг татахад Монгол Улсын үнэт цаасны зах зээл дээр олон улсын ангиллын мэргэжилтнүүд шаардлагатай байгааг харгалзан Монголын хөрөнгийн зах зээлийн мэргэжилтнүүдийг Итгэмжлэгдсэн санхүүгийн шинжээчдийн /CFA<sup>1</sup>/ болон Олон улсын хөрөнгө оруулалтын магадлан итгэмжлэгдсэн шинжээчдийн холбоо /ACIIA<sup>2</sup>/-дын сургалт, шалгалтад хамруулан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сертификаттай мэргэжилтэн бэлдэх арга хэмжээ авна.

Санхүү, хөрөнгө оруулалтын шинжээчдийн Монголын холбоо байгуулж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын байгууллагад гишүүнээр элсэх зэргээр монголын мэргэжилтнүүд олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах, үйл ажиллагаандаа олон улсын стандарт нэвтрүүлэх, магадлан итгэмжлэлд хамрагдах боломж олгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ..

4. Мэргэжлийн байгууллагын эрсдэлийн удирдлагыг боловсронгуй болгох замаар системийн эрсдэлийг бууруулна. Мэргэжлийн байгууллагуудын эрсдэлийн үнэлгээний аргачлал, хөрөнгийн зохистой харьцааг тогтоон мөрдүүлж, эрсдэлийн үнэлгээг тогтмол

---

<sup>1</sup> Chartered Financial Analysts

<sup>2</sup> Association of Certified International Investment Analysts

гүйцэтгэдэг болгон түүнд тавих хяналтыг сайжруулж, эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүр шуурхай авч ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

5. Мэргэжлийн байгууллагаас үзүүлэх үйлчилгээний стандарт, чанарыг сайжруулж, цар хүрээг өргөжүүлнэ. Мэргэжлийн байгууллагуудын үйлчилгээний нийтлэг стандартыг тогтоон мөрдүүлж, учрах эрсдэлээс сэргийлнэ. Ялангуяа, захиалга авах, захиалга гүйцэтгэх, харилцагчдад төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, зөвлөгөө өгөх, харилцагчдыг эрсдэлээс сэргийлэх үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн баримт бичгийн бүртгэл, архивлалтыг сайжруулна.

6. Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санг бий болгож, мэдээллийн хяналт, шинжилгээ, судалгааны тогтолцоог сайжруулна. Хөрөнгийн зах зээл, түүнд оролцогчдын үйл ажиллагааны талаар дүн шинжилгээ хийх боломж бүхий мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, судалгаа, шинжилгээний өндөр чадавхи бүхий баг бүрдүүлж, Хорооны бүрэлдэхүүнд ажиллууна.

7. Үнэт цаас гаргагчийн зэрэглэл тогтоох, шинээр гаргах үнэт цаасны үнэ ханшийг тогтооход хараат бус дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлдэг хөндлөнгийн рейтингийн үйлчилгээг бий болгохыг дэмжинэ.

8. Дотоодын хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогчдын гадаад хамтын ажиллагааг дэмжинэ.

### 2.2.3. Зах зээл дэх бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, хөрвөх чадварыг сайжруулах

1. Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд газрын ашиглалтын лицензийг эзэмшигчид “Ашигт малтмалын тухай” хуульд заасны дагуу хувьцаагаа Монголын хөрөнгийн биржид бүртгүүлж, арилжаалах ажиллагааг эхлүүлэх талаар холбогдох яам, агентлагтай хамтран ажиллах, орд газрыг эзэмшигч этгээдийн үнэт цаасыг Монголын болон гадаад орны бирж дээр зэрэг арилжаалах боломж олгодог Монголын хадгаламжийн батламж гаргах зэрэг зах зээлийн арга хэрэглүүрийг ашиглах эрх зүйн зохицуулалтыг бий болгох санал боловсруулан холбогдох яамдад хүргэнэ.

Төрийн өмчит компаниудыг бүрэн хувьчлахаас өмнө хяналтын бус хувийг жижиг багцаар, тухайлбал, 5-10 хувиар багцлан хөрөнгийн зах зээл дээр арилжаалах бодлогыг хэрэгжүүлэх талаар Төрийн өмчийн хороотой хамтран ажиллана. Эдгээр үнэт цаасыг тэтгэврийн болон хамтын хөрөнгө оруулалтын сангууд, хөрөнгө оруулалтын банкны болон андеррайтерийн компаниуд, компанийн ажиллагсдын баг худалдан авахыг дэмжиж, стратегийн хөрөнгө оруулагчдад хэт том багц төвлөрөх явдлыг хязгаарлах бодлого баримтлах талаар санал боловсруулан Засгийн газар, холбогдох яамдад хүргэнэ. Үүний үр дүнд зах зээлд найдвартай үнэт цаасны нийлүүлэлт нэмэгдэж, төрийн өмчит томоохон компаниудын засаглалыг сайжруулах боломж нэмэгдэнэ.

Төрийн болон орон нутгийн өмчит компаниуд бонд гаргах, хувьцаа нэмж гаргах замаар санхүүжилтийн тогтвортой хямд эх үүсвэр олох явдлыг дэмжиж, эдгээр компанийн гадаад эх үүсвэрээр хийх санхүүжилтийн тодорхой хувьд хүргэх бодлого баримтлана.

2. Ипотекийн үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэн, түүнд оролцогч байгууллагуудыг бэхжүүлэх чиглэлээр холбогдох яам газруудтай хамтран ажиллана.

Хөгжлийн банк, орон сууцны санхүүжилтийн корпораци зэрэг байгууллагуудаас гаргасан үнэт цаасыг худалдан авахад тэтгэврийн сангийн хөрөнгийг ашиглах бодлого баримтлана.

3. Үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх нэг чиглэл нь санхүүгийн шинэ хэрэгсэл, түүний дотор арилжааны үнэт цаасыг эргэлтэд оруулах явдал мөн. Арилжааны үнэт цаасыг гаргах, эргэлтэд оруулах эрх зүйн үндсийг бий болгоно.

Өрийн бичиг болон векселийн /векселээс ялгаатай нь стандартчлагдсан журмын дагуу гаргаж, төвлөрсөн бүртгэлийн системд бүртгэгдэн, зохион байгуулалттай зах зээлд арилжигддаг/ аль сайн шинжүүдийг агуулсан, тогтоосон хэмжээний орлоготой, богино хугацааны төлбөрийн хэрэгслэл болох арилжааны үнэт цаасыг арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй компанийн эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх механизм болгон ашиглана. Үүний тулд арилжааны үнэт цаасыг Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд гаргаж, биржээр дамжуулан арилжаалах эрх зүйн зохицуулалтыг Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд тусгана.

4. Дэлхийн биржүүдийн холбооны зарчмын дагуу бүртгэлтэй компаниудад олон нийтэд чөлөөтэй арилжаалагдах хувьцааны доод хязгаарыг тогтоож зах зээлийн хөрвөх чадвар, шударга өрсөлдөөнийг хангадаг. Иймд дээрх хязгаарыг арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлийн шалгуур байдлаар үе шаттай тогтоон мөрдүүлнэ. /гаргасан нийт хувьцааны 25-аас доошгүй хувийг нийтэд арилжаална/

5. Деривативын тухай ойлголтыг хуулиар бүрэн зөв, тодорхойлж, Монголын нөхцөлд зайлшгүй шаардлагатай деривативын зах зээлийг хөгжүүлэх арга хэмжээ авна. Хүүгийн болон валютын эрсдэлийн хедж хэрэгслийн зах зээлийг хөгжүүлж, хамтын хөрөнгө оруулалтын байгууллагын төдийгүй экспорт-импортын худалдаанд оролцогч байгууллагын эрсдэлийг бууруулах чиглэлээр таваар дээр суурилсан гэрээний үүсмэл хэрэгслүүд бий болгож, үнийн хэлбэлзлэлээс гарах гадаад худалдааны үйл ажиллагааны эрсдлийг бууруулах арга хэмжээ авна.

Мэргэжлийн оролцогчийн хөрөнгийн зохистой харьцааг зөв тогтоох замаар мэргэжлийн оролцогчоос деривативийн арилжаа хийх үйл ажиллагааг зохицуулна.

6. Үнэт цаасаа олон улсын зах зээлд арилжаалах хүсэлтэй Монгол Улсын хуулийн этгээд эхлээд Монголын хөрөнгийн зах зээл дээр үнэт цаасаа гаргасан байх шаардлагыг хуульчлах санал боловсруулан эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. Хөгжиж байгаа орнууд ийм хэм хэмжээ тогтоосон туршлага нь дотоодын зах зээл дээр дутагдаж байгаа үнэт цаасны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх, стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл

ажиллагаа явуулж буй компаниуд үндэсний хэмжээнд ил тод ажиллах боломжийг нэмэгдүүлдэгийг харуулсан.

Хамтын хөрөнгө оруулалтын байгууллагууд гадаадын хөрвөх чадвар бүхий үнэт цаас бусад санхүүгийн хэрэгсэл хэлбэрээр хөрөнгө оруулах хэм хэмжээг тогтоох арга хэмжээ авна.

7. Олон улсын үнэт цаасны зах зээлийн хэрэгслүүд харилцан нэвтрэх боломжийг либералчлах чиглэлээр Санхүүгийн зохицуулах хороо Олон улсын Үнэт цаасны хороодын холбооны гишүүн орнуудтай харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах ажлыг эрчимжүүлнэ.

Гадаадын хуулийн этгээдийн үнэт цаасыг Монгол улсын үнэт цаасны зах зээлд байршуулах, арилжих зохицуулалтыг бий болгосноор дотоодын хөрөнгө оруулагчдад сонголт бий болгоно. Санхүүгийн тохиромжтой хэрэгсэл хомсдолтой байгааг арилгах зорилгоор гадаадын үнэт цаас гаргагчийн хэрэгслүүдийг тус улсын хөрөнгийн зах зээлд чөлөөтэй арилжигдах нөхцлийг бүрдүүлнэ.

Монголын хөрөнгө оруулагчдыг гадаадын үнэт цаасанд хөрөнгө оруулах нэмэлт нөхцлөөр хангахын тулд кастодиан байгууллага хооронд шилжүүлгийн харилцаа тогтоох, үнэт цаас гаргах төсөл, танилцуулгад тусгагдах, нийтэд нээлттэй болгох мэдээлэлд нэгдсэн шаардлага тавих талаар бусад орнуудын Үнэт цаасны зах зээлийг зохицуулагч байгууллагуудтай тохиролцон, хамтран ажиллана.

8. Анхдагч зах зээлд үнэт цаас гаргах, захиалга авах, урьдчилан захиалж, төлбөрийг хийсэн тохиолдолд эзэмшигчдийн өмчлөх эрхийг баталгаажуулах, үнэт цаасыг захилгаар эзэмшсэн стратегийн хөрөнгө оруулагч, үүсгэн байгуулагч, төсөл санаачлагч зэрэг этгээд тодорхой хугацаанд эзэмшиж байгаа үнэт цаасаа бүхэлд нь эсхүл хэсгийг нь арилжихгүй байх үүрэг хүлээлгэх, эсхүл үнэт цаас гаргагч тодорхой хугацаанд нэмж хувьцаа гаргахгүй байх үүрэг хүлээлгэх нөхцөл журам, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахтай холбогдсон зохицуулалт тогтооно.

9. Үнэт цаасанд хөрөнгө оруулахыг татварын бодлогоор дамжуулан дэмжинэ. Үнэт цаас гаргасан компани болон үнэт цаасаар хөрөнгө оруулалт хийсэн компани, иргэдэд татварыг хөнгөлөлт үзүүлэх, ногдол ашгийн орлогыг татвараас чөлөөлөх бодлого баримтална.

10. Компанийн засаглалын үндэсний кодексийг хэрэгжүүлэх ажиллагааг шат дараатай зохион байгуулна.

Кодексийг бүртгэлтэй компанийн удирдлагад сургалчлах сургалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулж, хэрэгжилтийг дүгнэх аргачлал боловсруулан, жил бүр дүгнэж байна. Үүнд Хөрөнгийн бирж, Компанийн засаглалын хөгжлийн төв болон бусад төрийн бус байгууллагын оролцоог идэвхжүүлнэ.

Үнэт цаас гаргагчдын үйл ажиллагааг зохицуулах, компанийн сайн засаглалын практикийг хэвшүүлэх ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор үнэт цаас гаргагчдын төлөөлөгчид оролцсон төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжинэ

Эдгээр байгууллагатай дараах чиглэлээр хамтран ажиллана:

1. Хувьцаат компанийн удирдлага, ажилтнуудад зориулсан компанийн засаглалын сургалт зохион байгуулах
2. Хувьцаат компани, зах зээлийн мэргэжлийн оролцогчдын бүртгэл тайланд НББОУС нэвтрүүлэх
3. Үнэт цаасны зах зээлийн оролцогчдын үйл ажиллагааны ил тод байдлыг хангах
4. Үнэт цаасны зах зээлийн боломжуудын талаарх компанийн удирдах болон санхүүгийн ажилтнууд, ажиллагсдын мэдлэг, мэдээллийг сайжруулах.

11. Үнэт цаас гаргагч компаниуд болон мэргэжлийн байгууллагууд бүртгэл тайлангийн олон улсын стандартад шилжих нь санхүүгийн тайлангийн системийг боловсронгуй болгох, тэдний үйл ажиллагааны ил тод байдлыг ханган, нийтэд хүргэж буй мэдээллийн бодит байдлыг хангаж, хөрөнгө оруулалтын зөв шийдвэр гаргахад чухал ач холбогдолтойг сурталчлах

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу НББ-ийн олон улсын стандартад шилжих үйл ажиллагааг үнэт цаасны зах зээлийн оролцогчдын хувьд тусгай хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлнэ. Үүнд:

- Үнэт цаасны зах зээлд оролцогчдод зориулсан бүртгэл, тайлангийн олон улсын стандартад нийцсэн сурах бичиг, гарын авлага боловсруулж бэлтгэх
- Мэргэшсэн нягтлан бодогчдын институттэй хамтран үнэт цаасны зах зээлд оролцогч байгууллагуудын мэргэжилтэн, нягтлан бодогч нарыг сургах, давтан сургах
- Үнэт цаасны зах зээлийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт оруулах
- Энэ талаар төрийн эрх бүхий байгууллага, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах
- Бүртгэл тайлангийн олон улсын стандартыг сурталчлан таниулах зэрэг арга хэмжээг цаашид авах болно.

12. Үнэт цаасны зах зээлийн оролцогч байгууллагуудын болон СЗХ-ны мэдээллийг нээлттэй болгосноор санхүүгийн үйлчилгээний хэрэглэгчдийн зах зээлийн эрсдэлийг бууруулах, зах зээл өрсөлдөөнтэй, үр ашигтай ажиллах боломжийг олгоно. Ийм учраас үнэт цаас гаргагч болон мэргэжлийн оролцогч компаниудын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг дээшлүүлэх арга хэмжээ авна.

Хувьцаат компаниудын үйл ажиллагаанд тавих хяналтын илүү үр ашигтай, төвлөрсөн хяналтын зарчмыг (Disclosure-Based Regulation) нэвтрүүлнэ.

Үнэт цаас гаргагч болон үнэт цаасны зах зээлийн бусад оролцогчдын үйл ажиллагааны тухай мэдээллийг хөрөнгө оруулагч болон бусад сонирхогч этгээдэд нээлттэй болгох журмыг боловсронгуй болгоно. Тухайлбал, Үнэт цаас гаргах танилцуулга, санхүүгийн тайланг электрон хэлбэрт оруулж, СЗХ-ны вэб сайтаар хөрөнгө оруулагч болон бусад сонирхогч этгээдэд хүргэх арга хэмжээ авна.

Хувьцаат компанийн үйл ажиллагаатай холбоотой нийтэд нээлттэй болгох мэдээллийг тодорхой болгоно.

Хувьцаат компаниуд мэдээллээ нийтэд хүргэх зардлыг бууруулах зорилгоор дүрэмдээ заасан бол компанийхаа веб сайтаар, цөөн хувьцаа эзэмшигчидтэй бол хаягаар нь хүргэдэг байх журам тогтооно.

2.2.4. Хөрөнгө оруулагчдыг идэвхижүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалах, зах зээлийн бус эрсдлийг бууруулах, томоохон сангууд хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг бүрдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх;

1. Ард иргэдийн хөрөнгө оруулалтын тухай, түүний дотор үнэт цаасаар хийх хөрөнгө оруулалтын талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн тусгай хөтөлбөр боловсруулан, хандивлагчдын тусламжтай хэрэгжүүлнэ. Үүнд:

Үнэт цаасны зах зээлийн холбоодын олон улсын зөвлөл /ICSA/ -өөс баталж, Үнэт цаасны хороодын олон улсын байгууллага /IOSCO/ -аас зөвлөмж болгосон “Хөрөнгө оруулагчдыг сургах шилдэг практикийн зарчмууд”-ыг нэвтрүүлэх, ашиглах талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах, төсөл хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

2. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор хөрөнгө оруулагчдын мэдээлэл авах эрх, үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах боломжоор хангагдах, эрх нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд нэхэмжлэл гаргах, учирсан хохирлоо барагдуулах эрхийн хэрэгжилтийг баталгаажуулах чиглэлээр холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл боловсруулна.

3. Хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг хөрөнгө оруулагчдад цаг тухай бүр, зардал багатайгаар, шуурхай хүргэх мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ.

4. Хөрөнгийн зах зээлийн талаарх хөрөнгө оруулагчдын мэдлэгийг дээшлүүлэх, эрсдэлийг бодитой үнэлсний үндсэн дээр хөрөнгө оруулалт хийх чадвартай болгоход чиглэсэн бүх шатны сургалтын ажиллагааг дэмжиж ажиллана. Үүний тулд ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт санхүүгийн зах зээл, түүний дотор хөрөнгө оруулалтын үндэс гэсэн тусгай хичээлийг нэмж оруулах талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн төв байгууллага, их дээд сургуультай хамтран ажиллана.

5. Иргэдийн хөрөнгийн зах зээлд оролцох оролцоог нэмэгдүүлэх, ялангуяа орон нутагт оршин суугаа иргэдэд үнэт цаасны арилжаанд оролцох, мэдээлэл авахтай холбогдсон аливаа үйлчилгээ авах боломжийг нэмэгдүүлнэ.

6. Хөрөнгө оруулагчдад хүргэх үйлчилгээний хөлсийг бууруулах, тэдгээрт татварын бодлогоор хөнгөлөлт үзүүлэх замаар үндэсний тогтвортой хөрөнгө оруулагчдын тоог нэмэгдүүлнэ.

7. Тэтгэврийн даатгалын санг бие даалгах, зах зээлийн зарчмынх нь дагуу удирдах үйл ажиллагааг эхлүүлнэ. Урт хугацааны болон хувийн тэтгэврийн даатгалын үйлчилгээг

дэмжиж, эрх зүйн орчныг бүрдүүлэх, институционал хөрөнгө оруулагчийн хувьд хөрөнгийн зах зээлийн оролцогч болохыг нь дэмжинэ.

Хөрөнгийн зах зээлийн хөгжилд банкны оролцоог дээшлүүлнэ.

8. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах, хамтын хөрөнгө оруулалтын хэлбэрүүдийг хөгжүүлэн дэмжих, хөрөнгө оруулалтын сан байгуулах, сангийн активыг итгэмжлэн удирдах, бүртгэх, хадгалах, сангийн гаргасан үнэт цаасыг байршуулах, эргэлтэнд оруулах, худалдан авахтай холбогдсон харилцааг зохицуулж, хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлнэ.

Гадаадын хөрөнгө оруулалтын сан Монгол Улсад үйл ажиллагаа явуулахыг хүлээн зөвшөөрөх эрх зүйн зохицуулалтыг бий болгож, Хороонд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг хянах чадавхи бүхий мэргэжилтнүүдийг бэлтгэнэ

#### 2.2.5. Үнэт цаасны зах зээлийн зохицуулалтыг боловсронгуй болгох

Үнэт цаасны зах зээлийн төрийн зохицуулалтын гол чиглэл хамтын хөрөнгө оруулалтын сан, хувьцаат компани, үнэт цаасны зах зээлийн өөрийн зохицуулалттай болон мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны зохицуулалтыг боловсронгуй болгоход чиглэгдэнэ.

1. Хувьцаат компаниудын үйл ажиллагаанд хийх мониторингийн агуулгыг хуулиар тодорхойлж, түүнд хамрагдах компаниудын тоог нэмэгдүүлнэ.

**2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн төсөл** боловсруулж батлуулснаар хамтын хөрөнгө оруулалтын байгууллага үйл ажиллагааг явуулах, гадааданы хамтын хөрөнгө оруулалтын байгууллагыг хүлээн зөвшөөрөх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

**3. Хувьцаат компанийн тухай** хуулийг бие даасан хуулийн түвшинд боловсруулах асуудлыг судална. Одоогийн хуульд дараах чиглэлийн асуудлыг тусган нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулна.

- “нэгдмэл сонирхолтой этгээд”-ийн тухай ойлголтыг тодорхой болгон өргөжүүлэх замаар ХК-ийн хувьцааны багцыг эзэмшигчдийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх

- зохицуулагч байгууллагын хувьд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах тодорхой бүрэн эрх олгох /шүүхэд хандах, татан буулгах, өөрчлөн байгуулах г.м/

- тендер санал гаргах, ХК-г ХХК болгон өөрчлөх үед хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг тодорхойлох зарчмыг өөрчлөх

- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд тавих шаардлагыг тодорхой болгох, эрх бүхий байгууллага тохиромжтой этгээд гэж үзсэн этгээдийг ТУЗ-д болон гүйцэтгэх удирдлагад сонгох, ТУЗ хараат бус гишүүдтэй байх шаардлагыг хуульчлах, хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох, тэдгээр гишүүд нь үйл ажиллагаагаа тайлагнах журмыг хуульчлах

- хөрөнгө оруулагчдыг мэдээллээр хангах, компанийн үйл ажиллагааны ил тод байдлыг хангах чиглэлээр ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үүрэг хариуцлагыг тодорхой болгох,

4. Дараах чиглэлийн асуудлыг бүрэн тусгасан **Үнэт цаасны зах зээлийн тухай** хуулийн шинэчлэсэн найруулгын төсөл боловсруулна:

- Дотоод мэдээлэл ашиглан хийсэн хэлцэл, зах зээлийн манипуляцийг тодорхойлох чиглэлээр зах зээлд тавих хяналт, шалгалт, дотоод мэдээлэл эзэмшигчийн үйл ажиллагаанд хяналт тавих зарчим,
- Үнэт цаасны зах зээлийн мэдээллийг нээлттэй болгох
- Зах зээлийн дэд бүтцийн үндсэн байгууллага болох арилжаа эрхлэх болон төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллага, мэргэжлийн байгууллагуудад тавих, хөрөнгө, санхүүгийн шаардлага, зохистой харьцааны үзүүлэлт
- Үнэ ханшийг зохиомлоор өсгөх, бууруулах, нэг түвшинд барих, тодорхой үнэт цаасны арилжаа идэвхитэй явагдаж байгаа мэт сэтгэгдэл төрүүлэхэд чиглэсэн зах зээлийн манипуляци зэрэг үнэт цаасны зах зээл дээрх хууль бус үйл ажиллагааг тодорхойлох, сэргийлэх, хяналт тавих
- Үнэт цаасны зах зээлийн дэд бүтцийн байгууллагуудын үйл ажиллагаагны стандарт, горим, техник, програмын системд тавих шаардлага г.м.
- Нийтэд санал болгон үнэт цаас гаргах үйл ажиллагааны зохицуулалт, үнэт цаас гаргачдын үйл ажиллагаанд тасралтгүй хяналт тавих талаар зорхицуулах байгууллагын эрх үүргийг тодорхой болгох,

5. **Үл хөдлөх эд хөрөнгийн барьцаагаар баталгаажсан үнэт цаасны тухай** хуулийн төсөл боловсруулж батлуулан ипотекийн хоёрдогч зах зээлийг хөгжүүлнэ.

6. Эрүүгийн болон Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж, Үнэт цаасны зах зээлдээр үйлдэгддэг гэмт хэргийг одоогийнх шиг хохирлын хэмжээгээр биш гэмт үйлдлийн /объектив тал/ мөн чанараар нь тодорхойлох журамд шилжинэ.

## **7. Төрийн зохицуулалтын тогтолцоог шинэчлэх, чадавхижуулах.**

7.1. Санхүүгийн зах зээлийн зохицуулалт, бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг ханган ажиллаж буй Монгол банк, Сангийн яамтай үйл ажиллагааны уялдааг сайжруулж, хамтын зөвлөлдөх ажиллагааг тогтворжуулна.

7.2. Санхүүгийн салбарт тулгамдаж буй асуудлын шалтгаан, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлаар зөвлөлдөх чиглэлээр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулна.

7.3. Санхүүгийн зах зээлд оролцогчдын талаар төрийн байгууллагуудад төвлөрч буй мэдээллийн нэгдсэн сан, зайны болон газар дээрх хяналтын нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх талаар холбогдох яам, агентлагуудтай хамтран ажиллана. Ялангуяа хуулийн этгээдийн бүртгэл, татвар төлөгчийн мэдээлэл, иргэний болон эд хөрөнгийн бүртгэлийн мэдээлэл, хууль хяналтын байгууллага, шүүхийн шийдвэр, шийдвэр гүйцэтгэх байгууллага, өр барагдуулах албанд төвлөрч буй мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн санг үнэт цаас гаргач, хамтын хөрөнгө оруулалтын болон зах зээлийн өөрийн зохицуулалттай байгууллага, мэргэжлийн байгууллага бүрээр бүрдүүлэх замаар компанийн нийгмийн хариуцлага, засаглалын байдалд нэгдсэн дүгнэлт өгөх, аливаа тендер болон бусад шалгаруулалтад ашиглах, эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд мөн болох талаар дүгнэлт өгөх боломж бүрдүүлнэ.

7.4. Хорооны чиг үүргийг улс орны хэмжээнд хэрэгжүүлэхэд шаардлагатай зайны болон газар дээрх хяналт, шалгалтын чадавхийг нэмэгдүүлнэ. Хөрөнгийн зах зээлд оролцогчид болох үнэт цаас гаргач, үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага, үнэт

цаасны төлбөр, тооцоо, хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага, хөрөнгө оруулалт, хөрөнгө оруулалтын зөвлөх болон андеррайтер, брокер, дилерийн компанийн үйл ажиллагаанд тавих зайны хяналтыг цахим мэдээллийн санд тулгуурлан хийх боломж бүрдүүлнэ. Ялангуяа үнэт цаасны арилжаа, төлбөр, тооцоо, хадгаламжийн үйл явцад тавих хяналтын тусгайлсан цахим програмын хэрэглээг нэвтрүүлнэ.

7.5. Хорооны боловсон хүчний чадавхийг дээшлүүлж, тэдгээрийн мэргэшлийн түвшинг нэмэгдүүлэн, үйл ажиллагааны нээлттэй, ил тод, шударга, шуурхай ажиллагааны стандартыг бий болгон мөрдөж ажиллуулна.

7.6. Хөрөнгийн зах зээлийн оролцогчдын өөрийгөө зохицуулах байгууллагын үйл ажиллагааг дэмжин, олон нийтийн зүгээс идэвхитэй хяналт тавих боломжийг нэмэгдүүлнэ.

7.7. Хорооны санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, зохицуулах үйлчилгээний хөлснөөс төвлөрүүлсэн хөрөнгийг зах зээлийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх, түүний дэд бүтэц, мэргэжлийн оролцогчдын чадавхийг сайжруулах зориулалтаар ашиглах боломж олгох талаар санал боловсруулан, УИХ, Засгийн газарт хүргүүлнэ.

## **ГУРАВ. ХҮЛЭЭГДЭЖ БҮЙ ҮР ДҮН**

Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ гэж тооцсон болно. Үүнд:

1. Хөрөнгийн зах зээлийн дэд бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн, үйл ажиллагааны стандартыг сайжруулж, системийн эрсдлийг бууруулж уг зах зээлийг либеральчлах, гадаад болон дотоодын хөрөнгө оруулагчдад таатай орчныг бий болгосон байна.

2. Хөрөнгийн зах зээл дээр арилжаалагддаг санхүүгийн хэрэгслийн чанарыг сайжруулж, мэдээллийн нээлттэй байдал, олон нийтийн хяналтыг дээшлүүлж, зах зээлийн шударга практикийг хэвшүүлсэн байна. Хөрөнгийн биржийн бүртгэлийн шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн шаардлага хангасан компанийн хувьцаа нийтэд арилжаалагддаг болох нөхцлийг бүрдүүлэхийн хамт жижиг дунд үйлдвэрийн салбараас хөрөнгийн зах зээлд оролцох боломжийг давхар бүрдүүлнэ.

3. Хөрөнгийн зах зээлийн үнэлгээний дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг 2 дахин нэмэгдүүлнэ.

4. Хөрөнгө оруулагчдын эрх ашгийн хамгаалах эрх зүйн орчныг олон улсын стандартад хүргэн сайжруулж, өмч хувьчлалын улмаас үүссэн гажуудлыг арилгасан байна.

5. Хөрөнгийн зах зээл дэх мэдээллийг нээлттэй болгож, үнэт цаас гаргагчдын хувьд зохицуулалтын Мэдээлэлд суурилсан зохицуулалтын зарчим, мэргэжлийн оролцогчдын хувьд Эрсдэлд суурилсан зохицуулалтын зарчмыг нэвтрүүлсэн байна.

6. Өөрийгөө зохицуулах байгууллагын статусыг тодорхой болгохын хамт санхүүгийн бие даасан байдал, мэргэжилтнүүдийн чадавхийн дээшлүүлсэн байна.

7. Олон нийтийн санхүүгийн мэдлэг, боловсрол, сургалт, сурталчилгааны нэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр 16-гаас дээш насны нийт иргэдийн талаас багагүй хувь нь хөрөнгө оруулалтын үндсэн мэдлэгтэй болсон, хөрөнгийн за зээлд ямар нэг хэлбэрээр оролцдог болсон байна.

8. Санхүүгийн сургалтын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлсэн байна.

9. Хорооны гадаад хамтын ажиллагааг бэхжүүлж, гадаадын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй дотоодын иргэн, хуулийн этгээд хийгээд дотоодын зах зээлд үйл ажиллагаа явуулж буй гадаадын иргэн хуулийн этгээдийн талаар мэдээлэл солилцох, хяналт тавих, туршлага солилцох боломжийг бүрдүүлсэн байна.

## **ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ**

Хөтөлбөрийн хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөс гадна Хорооны зохицуулалтын үйлчилгээний хөлс, гадаад дотоодын хандив, тусламж хийгээд бусад хөрөнгийн эх үүсвэрээр бүрдүүлж ажиллана.